

Засгийн газраас баталсан “НОГООН ХУВЬСГАЛ” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл	
1	Хөтөлбөрийг баталсан огноо	Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 169 дүгээр тогтоол	
2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа	2005-2012 он, 8 жил	
3	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрийн эхний үе шатанд олсон ололтоо бататгах, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн усалгаатай тариаланг хөгжүүлж, өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод хамгаалагдсан хөрсний аж ахуйг эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах	
4	Хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> 1. Төв суурингийн айл өрх усалгаатай, хучлагатай талбай, хүлэмж, бүхээг /туннель/-эн байгууламж бий болгож төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж эхний ээлжинд өөрийн хэрэгцээг хангах, цаашид зах зээлд борлуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх; 2. Хүнсний ногоог хамгаалагдсан хөрсөнд тариалах замаар хүнсэнд шинэ ногоог хэрэглэх хугацааг уртасгах, таримлын нэр төрлийг олшруулж ургацыг нэмэгдүүлэх; 3. Эрт ургацын шинэ ногоог зах зээлд хүрэлцэх хэмжээгээр тасралтгүй нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; 4. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг өрх бүр боломжтой бүх нөхцөлийг ашиглан худаг, цас борооны усыг хэмнэлттэй зарцуулах арга технологийг эзэмшин хэрэглэж занших; 5. Өөрийн орны нөхцөлд тохирсон загвар хийцийн хүлэмж, бүхээг, тэдгээрийг хийх зориулалтын материал, цагаан болон хар өнгийн нийлэг хальс зэргийг гадаадаас оруулах, дотооддоо үйлдвэрлэх зэргээр түүний олноц хангамжийг хот, хөдөөд нэмэгдүүлэх; 	
5	Хүлээгдэж буй үр дүн	2005-2008 он	<ul style="list-style-type: none"> - Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг өрх, иргэдийн тоо одоогийнхоос 30-аас доошгүй хувиар; - Хураан авсан ургац 25-аас доошгүй хувиар нэмэгдсэн байна. - Өрхийн тариалангийн 70-аас доошгүй хувийг усалгаатай болгоно. - Хүнсний ногооны ургацын 15 хувийг хамгаалагдсан хөрснөөс авдаг болж - Төмс, хүнсний ногооны нэг га-гийн ургацыг 25 хувиар нэмэгдүүлнэ - 25-30 мянган ажлын шинэ байр бий болж - Хөтөлбөрт хамрагдсан өрхийн орлого 25-30хувиар нэмэгдэнэ.
		2009-2012 он	<ul style="list-style-type: none"> - Өрх, жижиг аж ахуйн нэгж, фермерийн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний талбай усалгаатай болж, - Хураан авсан хүнсний ногооны ургацын 30 хувийг хамгаалагдсан хөрснөөс авна. - Нэгж талбайгаас хураан авах хүнсний ногооны ургацыг 2004 оныхоос 40 хувиар нэмэгдүүлж, - Төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 70 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангана. - Хот суурин газрын тариалангийн талбайн хэмжээ 2004 оныхоос 30 хувь, хураан авч буй ургац 50 хувь нэмэгдэж, ажлын байрны тоо 2006 оныхоос 15 хувь, өрхийн орлого 40 хувиар нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. - Хамгаалагдсан хөрсний ногооны аж ахуй нийт үйлдвэрлэлийн

			талбайн 60 хувьд хүрч дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж экспортлож эхэлнэ. - 2004 оныхоос төмс, хүнсний ногоо тариалдаг өрхийн орлого 50 хувь, ажлын байр 50-60 мянгаар нэмэгдэнэ.							
6	Зардал сая төгрөг	Төсөв шаардагдах нийт зардал	Нийт 4910.0 сая төгрөг (улсын төсвөөс 2856.0 сая, орон нутгийн төсвөөс 48.0 сая, гадаадын зээл тусламж, төслөөс 630.0 сая, газар тариаланг дэмжих сангаас 1316 сая төгрөг)							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	8139.9 сая төгрөг							
		Тухайн жилд зарцуулсан	1841.0 сая төгрөг (улсын төсвөөс 44.1 сая, хөтөлбөрийн хуримтлалаас 27.8 сая, орон нутгийн төсвөөс 116.2 сая, бусад 1652.8 сая төгрөг)							
7	Хөтөлбөрийн хэрэгжилт /хүрсэн үр дүн, үр ашиг, үр нөлөө/		<p>Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 1029 аж ахуйн нэгж, 63.3 мянган өрх төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуй эрхлэн 11.2 мянган га-гаас 130.5 мянган тонн төмс, 5.6 мянган га-гаас 68.9 мянган тонн хүнсний ногоо, 542.2 га-гаас 247.8тонн жимс жимсгэнэ хураан авч, 580.4 мянган шил хүнсний ногоог даршилж боловсруулан зах зээлд борлуулж өрхийн дундаж орлогоо 390.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.</p> <p>Орон нутагт 378 агропарк тогтмол үйл ажиллагаа явуулж, 35.4 мянган хүнийг 1151удаагийн сургалтад хамруулан, 41.2 мянган ширхэг гарын авлага, зөвлөмжөөр ханган ажилласан ба гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдээс давхардсан тоогоор 276 төсөл орон нутагт хэрэгжиж 16.8 мянган хүнийг хамруулсан байна.</p> <p>Мөн өвлийн 12.5 га хүлэмжнээс 390.0 тонн, зуны 31.4 га хүлэмжнээс 449.2 тонн, 75.6 га хучлагатай талбайгаас 945.8 тн ургац хураан авсан байна.</p> <p>2009 онд улсын хэмжээгээр 13.1 мянган га-гаас 156.0 мянган тонн төмс, 6.53 мянган га-гаас 81.5 мянган тонн хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөрийн 2 дахь үе шат батлагдсан 2004 онтой харьцуулбал төмс, хүнсний ногоо тариалсан талбай 5.7 мянган га-гаар буюу 40.7 хувь, хураан авсан ургац 108.1 мянган тонноор буюу 83.5 хувь нэмэгдлээ.</p> <p>Хөтөлбөр хэрэгжсэнээр 2009 онд 2004 оныхоос хамгаалагдсан хөрсний талбай 90.02 га-гаар, зоорийн тоо 5777-оор, багтаамж 67.7 мянган тонноор тус тус нэмэгдсэн ч, хамгаалагдсан хөрснөөс хураан авсан ургац 213.9 тонноор буурч зоорийн хүч чадлын 20.0 хувийг л ашигласан, усалгаатай төмс, хүнсний ногооны нэгжийн ургац өсөхгүй байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтаар олгосон усалгааны систем, хүлэмж, нийлэг хальс зэрэг техник хэрэгсэлийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна.</p>							
8	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	8	2	2	1	1	1	1	
9	Шалгуур үзүүлэлт		Төлөвлөсөн			Гүйцэтгэл			Хувь	
	а/ Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг: өрхийн тооны өсөлт		Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг өр-хийн тоо 130% болно.			Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрхийн тоо 47320 болсон нь 2004 оны 37.2 хувь болжээ.			28.6	
	б/ Хураан авсан нийт ургацын өсөлт		Хураан авсан нийт ургац: төмс 125 % хүнсний ногоо 150 % жимс, жимсгэнэд 125 %			Хураан авсан нийт ургац төмс 219.7 % хүнсний ногоо 195.1 % жимс, жимсгэнэд 124.0 %			175.7 130.1 99.2	

	болж тус тус өснө	тус тус өслөө	
в/ Өрхийн тариаланд усалгаатай тариалангийн эзлэх хувь	Өрхийн тариаланг 100 хувь усалгаатай болгоно.	Улсын хэмжээгээр төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний 14395.2 га талбай усалгаатай болсон нь өрхийн тариалангийн 82.7 % боллоо.	82.7
г/ Хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургацын эзлэх хувь	Хүнсний ногооны ургацын 30 хувийг хамгаалагдсан хөрснөөс авдаг болсон байх	Хамгаалагдсан хөрснөөс 1785.0 тн хүнсний ногоо хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацын 1.37 хувь болжээ,	4.6
д/ Нэг га-гийн ургацын өсөлт	Нэг га-гийн ургац: төмсөнд 125 %, хүнсний ногоонд 140 % болж нэмэгдэнэ	. Нэг га-гийн ургац: төмсөнд 125.9 %, хүнсний ногоонд 124.8 % болж нэмэгдлээ	100.7 89.1
е/ Төмс, хүнсний ногооны хангамж	Төмсний хэрэгцээг 100 %, хүнсний ногооны хэрэгцээг 70 % дотоодын үйлдвэрлэлээр хангана.	Төмсний хэрэгцээг 118.2 %, хүнсний ногооны хэрэгцээг 48.5 % дотоодын үйлдвэрлэлээр хангах боломж бүрдсэн.	118.2 69.3
е/ Ажлын шинэ байрны тоо	50-60 мянган ажлын шинэ байр бий болно	Ажлын байр 20872 болж, 2004 оныхоос 1830 ажлын байр шинээр нэмэгдсэн	41.7
ё/ Хөтөлбөрт хамрагдсан өрхийн орлогын өсөлт	Хөтөлбөрт хамрагдсан өрхийн орлого 150 % болж нэмэгдэнэ	Өрхийн дундаж орлого 390.5 мянган төгрөг нэмэгдсэн нь 2004 оныхоос 260.3 хувь болж өсчээ.	173.5
Нийт хэрэгжилт			92.8
10	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/	<p>Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 1029 аж ахуйн нэгж, 63.3 мянган өрх төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуй эрхлэн 11.2 мянган га-гаас 130.5 мянган тонн төмс, 5.6 мянган га-гаас 68.9 мянган тонн хүнсний ногоо, 542.2 га-гаас 247.8 тонн жимс жимсгэнэ хураан авч, хүнсний ногоог боловсруулж 580.4 мянган шилийг зах зээлд борлуулж өрхийн дундаж орлогоо 390.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.</p> <p>Орон нутагт 378 агропарк тогтмол үйл ажиллагаагаа явуулж, 35.4 мянган хүнийг 1151 удаагийн сургалтад хамруулан, 41.2 мянган ширхэг гарын авлага, зөвлөмжөөр ханган ажилласан ба гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдээс давхардсан тоогоор 276 төсөл орон нутагт хэрэгжиж 16.8 мянган хүнийг хамруулсан байна.</p> <p>Мөн өвлийн 12.5 га өвлийн хүлэмжнээс 390.0 тонн, зуны 31.4 га хүлэмжнээс 449.2 тонн, 75.6 га хучлагатай талбайгаас 945.8 тонн ургац хураан авсан байна.</p> <p>2009 онд улсын хэмжээгээр 13170 га-гаас 156018 тонн төмс, 6529 га-гаас 81475 тонн хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөрийн 2 дэхь үе шат батлагдсан 2004 онтой харьцуулбал төмс, хүнсний ногоо тариалсан талбай 5.7 мянган га-гаар буюу 40.7 хувь, хураан авсан ургац 108.1 мянган тонноор буюу 83.5 хувь нэмэгдсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлтээр нь үнэлэхэд нийт дундаж нь 92.8 хувьтай байгаа нь хангалттай үзүүлэлт юм.</p> <p>Хэдийгээр төмс, хүнсний ногооны нийт ургацын хэмжээ</p>	

		нэмэгдэж, хүнсний хангамжийг сайжруулах нөхцөл бүрдсэн ч төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрхийн тоо, жимс, жимсгэний нийт ургац, хүнсний ногооны нэг га-гийн ургац, өрхийн тариаланд усалгаатай тариаланд эзлэх хувь, , хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургацын эзлэх хувь, шинээр буй болгох ажлын байрны тоо зэрэг шалгуур үзүүлэлтүүд тавьсан зорилтдоо хүрсэнгүй.
11	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс	Усалгааны систем, хүлэмж, нийлэг хальс зэрэг хөрөнгө оруулалтаар олгож буй техник хэрэгслийн ашиглалт хангалтгүй, тэдгээрийг ашиглуулах талаар төв, орон нутгийн байгууллагын хяналт сул, тайлагнах тогтолцоо байхгүйгээс хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх 8 шалгуур үзүүлэлтээс 6 нь хүрэх түвшиндээ хүрсэнгүй.
12	Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаа төдийлөн сайнгүй байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	Хөтөлбөрийн хүрээнд үр, техник хэрэгслийг олгохдоо эзнийг зөв олж өгөх, тэдгээрийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай болохыг зөвлөж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА.

НОГООН ХУВЬСГАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

2009 оны жилийн эцсийн байдлаар

Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийн нэгдүгээр үе шат (1997-2004 он)-ыг 1997 онд баталж амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд хоёрдугаар үе шат(2005-2012 он)-ыг Засгийн газрын 2004 оны 169 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр 8 жил үргэлжлэх бөгөөд дотроо 2 үе шат болгон шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг 2005-2008 он, 2008-2012 оноор тодорхойлсон байна.

Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн эхний үе шатанд олсон ололтоо бататгах, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн усалгаатай тариаланг хөгжүүлж, өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод хамгаалагдсан хөрсний аж ахуйг эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах зорилготой. Үүний тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Төв суурингийн айл өрх усалгаатай, хучлагатай талбай, хүлэмж, бүхээг /туннель/-эн байгууламж бий болгож төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж эхний ээлжинд өөрийн хэрэгцээг хангах, цаашид зах зээлд борлуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх;
2. Хүнсний ногоог хамгаалагдсан хөрсөнд тариалах замаар хүнсэнд шинэ ногоог хэрэглэх хугацааг уртасгах, таримлын нэр төрлийг олшруулж ургацыг нэмэгдүүлэх;
3. Эрт ургацын шинэ ногоог зах зээлд хүрэлцэх хэмжээгээр тасралтгүй нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
4. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг өрх бүр боломжтой бүх нөхцөлийг ашиглан худаг, цас борооны усыг хэмнэлттэй зарцуулах арга технологийг эзэмшин хэрэглэж занших;
5. Өөрийн орны нөхцөлд тохирсон загвар хийцийн хүлэмж, бүхээг, тэдгээрийг хийх зориулалтын материал, цагаан болон хар өнгийн нийлэг хальс зэргийг гадаадаас оруулах, дотооддоо үйлдвэрлэх зэргээр түүний олдоц хангамжийг хот, хөдөөд нэмэгдүүлэх;

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн арга зам нь:

1. Өрхийн тариаланг хөгжүүлэх гол нөхцөлийн нэг болох усан хангамжийг нэмэгдүүлнэ.
2. Хамгаалагдсан хөрсөнд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлнэ.
3. Техникийн хангамжийг сайжруулна.
4. Ургац болон ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулна.
5. Үр, суулгацын хангамжийг сайжруулна.
6. Сургалт, сурталчилгаа

Хүлээгдэж буй зорилтын шалгуур үзүүлэлт нь:

Эхний үе шат /2005-2008 он/-анд:

- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг өрх, иргэдийн тоо одоогийнхоос 30-аас доошгүй хувиар;
- Хураан авсан ургац 25-аас доошгүй хувиар нэмэгдсэн байна.
- Өрхийн тариалангийн 70-аас доошгүй хувийг усалгаатай болгоно.
- Хүнсний ногооны ургацын 15 хувийг хамгаалагдсан хөрснөөс авдаг болж
- Төмс, хүнсний ногооны нэг га-гийн ургацыг 25 хувиар нэмэгдүүлнэ
- 25-30 мянган ажлын шинэ байр бий болж
- Хөтөлбөрт хамрагдсан өрхийн орлого 25-30хувиар нэмэгдэнэ.

Дараагийн үе шат /2009-2012 он/-анд:

- Өрх, жижиг аж ахуйн нэгж, фермерийн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний талбай усалгаатай болж,
- Хураан авсан хүнсний ногооны ургацын 30 хувийг хамгаалагдсан хөрснөөс авна.
- Нэгж талбайгаас хураан авах хүнсний ногооны ургацыг 2004 оныхоос 40 хувиар нэмэгдүүлж,
- Төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 70 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангана.

- Хот суурин газрын тариалангийн талбайн хэмжээ 2004 оныхоос 30 хувь, хураан авч буй ургац 50 хувь нэмэгдэж, ажлын байрны тоо 2006 оныхоос 15 хувь, өрхийн орлого 40 хувиар нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.
- Хамгаалагдсан хөрсний ногооны аж ахуй нийт үйлдвэрлэлийн талбайн 60 хувьд хүрч дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж экспортлож эхэлнэ.
- 2004 оныхоос төмс, хүнсний ногоо тариалдаг өрхийн орлого 50 хувь, ажлын байр 50-60 мянгаар нэмэгдэнэ.

Үйл ажиллагаа

1. Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрхийн тариаланг дэмжихэд зориулан 50 ширхэг 0.5 га-гийн дуслын усалгааны төхөөрөмж, 33600 м² талбай бүхий 230 иж бүрдэл нийлэг хальсан загвар хүлэмж /дуслын усалгааны төхөөрөмжтэй/, 1000 орчим га талбайд тариалах 1377 кг байцаа, шар лууван, хүрэн манжин, урт болон бөөрөнхий сонгино, шар манжин, өргөст хэмх зэрэг голлох хүнсний ногооны үр, чацарганы суулгац 20.0 мянга, үхрийн нүдний суулгац 20.0 мянган ширхэгийг худалдан авав. Монгол төмс хөтөлбөрөөс гэрээний дагуу үрийн төмс 85 тонныг авч ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 101 дүгээр, хүнсний ногооны үрийг 115 дугаар, хүлэмжийг 137 дугаар, дуслын усалгааны төхөөрөмжийг 302 дугаар тушаалаар 22 аймаг, нийслэлийн ХХААЖДҮ-ийн газар болон төмс, хүнсний ногоо тариалагч 176 иргэн, аж ахуйн нэгжүүдэд хуваарилан олгожээ. Мөн “Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг дэмжих” төсөл шалгаруулж 19 аймаг, нийслэлийн 78 иргэн, аж ахуйн нэгжид 920.0 сая төгрөгийн зээлийг Төрийн нарийн бичгийн даргын 131 дүгээр тушаалаар 5 жилийн хугацаагаар олгов.

Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, нийслэлийн иргэдийн хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Алтан намар” шинэ ургацын үзэсгэлэн худалдааг 09 дугаар сарын 18-24-ны өдрүүдэд “Мишээл экспо” төвд зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд 19 аймгийн 78 сум, нийслэлийн 3 дүүргийн 260 гаруй иргэн, аж ахуйн нэгж, 13 хоршоо, 5 төсөл оролцож, 68 нэр төрлийн 18.5 мянган тонн төмс, хүнсний ногоо, 21000 шил нөөшилсөн ногоо, 5.5 тонн орчим зөгийн бал, 2.5 тонн жимс, жимсгэнэ, 3000 ширхэг суулгац борлуулж, нийт 856.8 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Үзэсгэлэнгийн үеэр ЭМШУИС, ШУТИС-ийн байгууллага давхардсан тоогоор 4200 гаруй хүнд зөвлөгөө өгч, хүнсний ногоо боловсруулах сургалт сурталчилгаа хийж, амталгаат өдөрлөг зохион байгуулж, экспресс лаборатори ажиллуулав. “Алтан намар-2009” үзэсгэлэнд оролцогчдыг “Шилдэг сум”, “Шилдэг ногоочин”, “Шилдэг аж ахуйн нэгж, хоршоо” номинацид нэр дэвшүүлэн шалгаруулж, урамшуулжээ.

Мөн НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 8.0 гаруй өрхөд судалгаа хийж Өвөрхангай, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Төв, Ховд, Хөвсгөл, Улаанбаатар хотын бага, дунд орлоготой өрхүүдэд 600 тонн төмсний үр олгох ажлыг зохион байгуулав.

2. Сургалт, сурталчилгаа:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд зайн болон танхим, талбайн сургалт сурталчилгааг төв, орон нутгийн салбар штаб, гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүдээс нэвтрүүлэх төв, агропарк, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан тогтмол явуулж байна. Энэ онд “Ногоон хувьсгал” төв штабаас энэ талаар дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

“Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийн орон нутаг дахь хэрэгжилтийн байдалтай танилцах, ногоочдын туршлагыг солилцуулах, агропаркийн үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, айл өрхүүдийн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл, хүлэмжинд хүнсний ногоо тариалах шинэ технологи хэрхэн нэвтэрч байгааг олон нийтэд сурталчлах зорилготой “Ногоон хувьсгал” үзүүлэх сургуулийг 8 дугаар сарын 20-22-ний өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулав. Үзүүлэх сургалтад 16 аймаг, нийслэлийн 10 дүүргийн 120 төлөөлөгч оролцсон ба хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл сэдвээр сургалт зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллав. Ховд аймагт баруун бүсийн хөдөө аж ахуйн өдөрлөг болж байсан тул баруун 5 аймгийн төлөөлөгчид энэ үзүүлэх сургуульд оролцоогүй байна.

Хүнсний ногооны талбайг нийлэг хальсаар бүтээн чийгийн ууршилтыг бууруулах, хог ургамлын ургалтыг хязгаарлах, дулаан хуримтлуулах замаар ургац нэмэгдүүлэх арга технологийг нийтэд дэлгэрүүлэх сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хүлэмжинд хүнсний ногоо тариалах технологи” сургалтыг Улаанбаатар хотын

Сонгинохайрхан дүүргийн “Түмэн сүйх” ХХК-ний хүлэмжинд БНСУ-ын Койка байгууллагын шугамаар ирсэн багш Канг Гуан Юн, “Түмэн сүйх” ХХК-ний агрономч Я.Оюунчимэг нар зааж, сургалтад 100 гаруй ногоочид оролцов.

Мөн нийслэлийн Захирагчийн албатай “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, санамж бичгийн дагуу 6 дүүрэгт “Хүлэмжийн агаар, чийг, дулаан зохицуулах горим”, “Хүлэмжийн ногооны ургамал хамгаалал”, “Хүлэмжинд жимс, жимсгэнэ тариалах технологи” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж 200 гаруй ногоочдыг хамруулан сертификат олгов.

“Хүнсний ногооны тариалалт, ургамал хамгаалал, боловсруулалт, хадгалах” сэдэвт сургалтыг Төв, Дархан-Уул аймагт зохион байгуулж 210 гаруй ногоочид оролцов.

Өрхийн аж ахуй эрхэлж байгаа тариаланчдад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тариалангийн салбарт гарч байгаа шинэ дэвшилтэт технологи, арга барилыг дэлгэрүүлэх чиглэлээр Монголын радиогоор “Газар дэлхийн шим” нэртэй цуврал нэвтрүүлгийг 24 удаа бэлтгэн явуулав.

Үр дүн, үнэлгээ

Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 1029 аж ахуйн нэгж, 63.3 мянган өрх төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуй эрхлэн 11.2 мянган га-гаас 130.5 мянган тонн төмс, 5.6 мянган га-гаас 68.9 мянган тонн хүнсний ногоо, 542.2 га-гаас 247.8 тонн жимс жимсгэнэ хураан авч, хүнсний ногоог боловсруулж 580.4 мянган шилийг зах зээлд борлуулж өрхийн дундаж орлогоо 390.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Орон нутагт 378 агропарк тогтмол үйл ажиллагаагаа явуулж, 35.4 мянган хүнийг 1151 удаагийн сургалтад хамруулан, 41.2 мянган ширхэг гарын авлага, зөвлөмжөөр ханган ажилласан ба гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдээс давхардсан тоогоор 276 төсөл орон нутагт хэрэгжиж 16.8 мянган хүнийг хамруулсан байна.

Мөн өвлийн 12.5 га өвлийн хүлэмжнээс 390.0 тонн, зуны 31.4 га хүлэмжнээс 449.2 тонн, 75.6 га хучлагатай талбайгаас 945.8 тонн ургац хураан авсан байна.

2009 онд улсын хэмжээгээр 13170 га-гаас 156018 тонн төмс, 6529 га-гаас 81475 тонн хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөрийн 2 дэхь үе шат батлагдсан 2004 онтой харьцуулбал төмс, хүнсний ногоо тариалсан талбай 5.7 мянган га-гаар буюу 40.7 хувь, хураан авсан ургац 108.1 мянган тонноор буюу 83.5 хувь нэмэгдсэн байна. /Хүснэгт-1/

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлтээр нь үнэлэхэд нийт дундаж нь 92.8 хувьтай байгаа нь **хангалттай** үзүүлэлт юм. /Хүснэгт-2/

Хэдийгээр төмс, хүнсний ногооны нийт ургацын хэмжээ нэмэгдэж, хүнсний хангамжийг сайжруулах нөхцөл бүрдсэн ч төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрхийн тоо, жимс, жимсгэний нийт ургац, хүнсний ногооны нэг га-гийн ургац, өрхийн тариаланд усалгаатай тариалангийн эзлэх хувь, хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургацын эзлэх хувь, шинээр буй болгох ажлын байрны тоо зэрэг шалгуур үзүүлэлтүүд нь тавьсан зорилтдоо хүрээгүй байна.

Хөтөлбөр хэрэгжсэнээр 2009 онд 2004 оныхоос хамгаалагдсан хөрсний талбай 90.02 га-гаар, зоорийн тоо 5777-оор, багтаамж 67.7 мянган тонноор тус тус нэмэгдсэн ч хамгаалагдсан хөрснөөс хураан авсан ургац 213.9 тонноор буурч, зоорийн хүч чадлын 20.0 хувийг л ашигласан, усалгаатай төмс, хүнсний ногооны нэгжийн ургац өсөхгүй байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтаар олгосон усалгааны систем, хүлэмж, нийлэг хальс зэрэг техник хэрэгсэлийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна.

Хөрөнгө оруулалтаар олгож буй техник хэрэгсэлийн ашиглалт хангалтгүй байгаа нь тэдгээрийн ашиглалтад тавих төв орон нутгийн байгууллагын хяналт сул, тайлагнах тогтолцоо байхгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Иймд хөтөлбөрийн хүрээнд үр, техник хэрэгслийг олгохдоо эзнийг зөв олж өгөх, тэдгээрийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай болохыг зөвлөж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хүснэгт 1, улсын хэмжээний төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, импорт, хэрэглээний зарим үзүүлэлийг хүснэгт-2-оор харуулж хавсаргав.

“НОГООН ХУВЬСГАЛ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
/ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР/

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрсэн түвшин оноор		2009/ 2004, %	
		2004	2009		
1. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг: өрхийн тоо	тоо	126882	47320	37.3	
2. Хураан авсан нийт ургац	Төмс	тн	59413	130528.3	219.7
	Хүнсний ногоо	тн	35354	68961.6	195.1
	Жимс жимсгэнэ	тн	199.8	247.8	124.0
3. Нэг га-гийн ургац	Төмс	цн	92.3	116.2	125.9
	Хүнсний ногоо	цн	98.4	122.8	124.8
	Жимс жимсгэнэ	цн	10.6	4.57	43.1
4. Нийт тарьсан талбай	Төмс	га	6436.4	11236.9	174.5
	Хүнсний ногоо	га	3590.7	5613.9	156.3
	Жимс жимсгэнэ	га	187.5	542.2	289.2
5. Усалгаатай тарьсан	Төмс	га	5111.8	8190.0	160.2
	Хүнсний ногоо	га	4247.1	5515.0	129.8
	Жимс жимсгэнэ	га	250.7	690.2	275.3
	Өрхийн тариаланд усалгаатай тариалангийн эзлэх хувь	хувь	94.1	82.7	87.9
6. Бүгд хамгаалагдсан хөрс	Талбайн хэмжээ	га	29.55	119.57	404.6
	Хураасан ургац	тн	1998.9	1785.0	89.3
	Хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургацын эзлэх хувь	хувь	5.65	1.37	24.2
7. Төмсний хангамж	Хэрэгцээ	мян.тн		132.0	
	Дотоодын үйлдвэрлэл	мян.тн	80.2	156.0	
	Хангамж	хувь		118.2	
8. Хүнсний ногооны хангамж	Хэрэгцээ	мян.тн		168.0	
	Дотоодын үйлдвэрлэл	мян.тн	49.2	81.5	
	Хангамж	хувь		48.5	
7. Нийт ажлын байр	тоо	10034	20872	208.0	
8. Өрхийн дундаж орлого	мян.төг	150.0	390.5	260.3	

**“НОГООН ХУВЬСГАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
2009 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

№	Шалгуур үзүүлэлт		Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин		Үнэлгээ, %
				Зорилт	Хэрэгжилт	
1	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг: өрхийн тооны өсөлт		хувь	130	37.2	28.6
2	Хураан авсан нийт ургацын өсөлт	Төмс	хувь	125	219.7	175.7
		Хүнсний ногоо	хувь	150	195.1	130.1
		Жимс, жимсгэнэ	хувь	125	124.0	99.2
3	Өрхийн тариаланд усалгаатай тариалангийн эзлэх хувь		хувь	100	82.7	82.7
4	Хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургацын эзлэх хувь		хувь	30	1.37	4.6
5	Нэг га-гийн ургацын өсөлт	Төмс	хувь	125	125.9	100.7
		Хүнсний ногоо	хувь	140	124.8	89.1
6	Хангамж дотоодын	Төмс	хувь	100	118.2	118.2
		Хүнсний ногоо	хувь	70	48.5	69.3
7	Ажлын шинэ байрны тоо		тоо	50000	20872	41.7
8	Хөтөлбөрт хамрагдсан өрхийн орлогын өсөлт		хувь	150	260.3	173.5
Бүх нийлбэр хувь						1113.4
Нийт дундаж хэрэгжилт						92.8

“НОГООН ХУВЬСГАЛ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Үзүүлэлт		Хүрэн түвшин, онуудаар						2009/ 2004, %
		2004	2005	2006	2007	2008	2009	
1. Хөтөл- бөрт хам- рагдсан	Өрх	126882	128067	131012	131511	104391	47320	37.3
	Аж ахуйн нэгж. байгууллага	1393	1169	1242	1135	979	719	51.6
2. Хөтөлбөрийн хүрээнд тариалсан талбай, га		10214.6	9863.2	13358.9	13976.6	15693	17393.0	170.3
Үүнээс	Төмс	6436.4	5868.0	7905.7	8441.6	9836.6	11236.9	174.6
	Хүнсний ногоо	3590.7	3802.0	5091.2	5158.2	5267.6	5613.9	156.3
	Жимс, жимсгэнэ	187.5	193.2	362.0	376.7	588.8	542.2	289.2
Үүнээс усалгаатай, га		9609.6	4395.0	8942.4	10661.5	16371.2	14395.2	149.8
3. Хураа- сан ургац	Төмс, мян.тн	59.4	50.3	94.2	91.9	105.8	130,53	219.7
	Хүнсний ногоо, мян.тн	35.3	40.3	64.2	65.3	61.5	68.96	195.3
	Жимс, жимсгэнэ, тн	199.8	220.5	1576.0	621.7	479.5	247.8	124.0
4.Нэг га-гийн ургац, цн	Төмс	92.3	85.7	119.1	108.9	107.6	116.2	125.9
	Хүнсний ногоо,	98.4	106.0	126.1	126.6	117.0	122.8	124.8
	Жимс, жимсгэнэ	10.6	11.4	43.5	16.5	8.1	4.57	43.1
5.Ажлын байр		10034				11864	20872	208.0
6. Ашиглаж буй зoorь	Тоо	4242	6533	10769	12118	10760	10019	236.2
	Багтаамж, мян.тн	35.0	82.2	92.5	71.8	98.3	102.7	293.4
7.Хамгаа- лагдсан хөрс бүгд	Талбайн хэмжээ, га	29.55	32.34	36.91	80.0	39.71	119.57	404.6
	Хураасан ургац, тн	1998.9	1994.4	7110.2	3670.6	1579.4	1785.0	89.3
Өвлийн хүлэмж	Тоо	-	24	26	9	22	25	-
	Нийт талбай, мян.м ²	85.0	90.1	92.0	5.2	125.4	125.5	147.6
	Хураасан ургац, тн	610.0	663.9	693.2	5.7	391.2	390.0	63.9
Зуны хүлэмж	Тоо	4229	4261	1254	3003	3308	3777	89.3
	Нийт талбай, мян.м ²	210.5	140.7	141.2	187.6	219.8	314.2	149.3
	Хураасан ургац, тн	1388.9	888.4	5971.7	1923.3	691.2	449.2	32.3
Нийлэг хальсан хvчдaгa	Нийт талбай, мян.м ²	-	92.6	135.9	607.2	51.9	756.0	-
	Хураасан ургац, тн	-	442.1	445.3	1741.6	497.0	945.8	-
8. Агропаркийн тоо		141	130	125	119	400	378	268.1
9.Сургалт	Тоо	890	931	939	825	931	1151	129.3
	Хамрагдсан хүн, мян	46.5	37.1	37.7	31.4	36.17	35.43	76.2

10. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл	Тоо	156	238	343	215	209	276	176.9
	Хамрагдсан өрх. мян	10.0	10.7	14.3	14.7	11.86	16.79	167.9
11. Хөтөлбөрт хамрагдсан өрхийн нэмэгдсэн дундаж орлого, мян.төг		150.0	160.0	202.0	207.2	390.5	390.5	260.3
12. Хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, сая төг		438.0	537.0	526.7	653.0	4144.2	1841.02	420.3

УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ,
ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

2010.02.09

Үзүүлэлт		Онууд						2009/ 2004
		2004	2005	2006	2007	2008	2009	
1 Тариалсан талбай, га	Төмс	9078.6	9757.8	10723.4	11461.5	12291.6	13170	145.1
	Хүнсний ногоо	4918.5	5887.9	5882.6	6134.5	6409.5	6529	132.7
2. Хураасан ургац, мян.тн	Төмс	80.2	82.8	109.1	114.5	134.8	156.0	194.5
	Хүнсний ногоо	49.2	64.1	70.4	76.5	78.9	81.5	164.6
Үүнээс	Байцаа	13.8	14.9	18.5				-
	Манжин	11.8	14.7	14.8				-
	Лууван	12.8	20.9	21.8				-
	Сонгино	1.7	2.8	3.0				-
	Өргөст хэмх	2.0	2.4	2.9				-
3. Нэг га-гийн ургац, цн	Төмс	88.3	84.8	101.7	99.9	109.6	118.5	134.2
	Хүнсний ногоо	100.0	109.0	119.7	125.0	123.1	124.8	124.8
4. Импортлосон, мян.тн	Төмс	38.4	41.0	35.6	30.2	35.4	23.2	60.4
	Жимс	22.9	22.6	15.3	17.1	16.94	17.54	76.6
	Хүнсний ногоо	18.3	16.2	21.0	24.58	50.44	49.77	272.0
Үүнээс	Байцаа	7.8	9.6	10.3	13.0	20.5	19.8	253.8
	Сонгино. сармис	9.5	5.5	4.3	1.9	14.3	11.2	117.9
	Лууван, манжин	1.0	1.1	0.6	5.5	5.7	15.1	-
	Улаан лооль				2.34	5.7	2.7	-
	Өргөст хэмх				1.84	4.24	0.97	-
5. Нэг хүнд ногдох үйлдвэрлэл, кг	Төмс	31.8	32.3	42.3	44.0	57.1	58.1*	101.7
	Хүнсний ногоо	19.5	25.0	27.3	30.0	32.4	30.4*	93.8

*-урьдчилсан дүн